



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-08-05 № 01/761
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Монгол хүний төлөө" намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Монгол хүний төлөө" намын Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монгол хүний төлөө" намын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: "Монгол хүний төлөө" намд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

019021078

1000



2024 ОНЫ
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2024 оны -р сарын -ны өдөр

АГУУЛГА:

1. **МХТН-ын үзэл баримтлал**
2. **Ерөнхий зүйл**
3. **Нийгэм, эрүүл мэнд, халамжийн бодлого**
 - 3.1. Эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх
 - 3.2. Хүн амын өсөлт
 - 3.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого
 - 3.4. Нийгмийн халамж
4. **Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого**
 - 4.1. Ерөнхий боловсрол
 - 4.2. Мэргэжлийн сургалт
 - 4.3. Соёл
 - 4.4. Шинжлэх ухаан
 - 4.5. Спорт
5. **Эдийн засаг үйлдвэрлэлийн бодлого**
 - 5.1. Төсөв, санхүү
 - 5.2. Хөдөө аж ахуй
 - 5.3. Газар тариалан
 - 5.4. Аж үйлдвэр
 - 5.5. Уул уурхай
 - 5.6. Эрчим хүч
 - 5.7. Зам тээвэр, дэд бүтэц
 - 5.8. Барилга, хот байгуулалт
 - 5.9. Аялал жуулчлал
6. **Төрийн байгуулалт, хууль зүйн бодлого**
 - 6.1. Улс төрийн шинэчлэл
 - 6.2. Төрийн алба
 - 6.3. Засгийн газрын бүтэц, үүрэг
 - 6.4. Хяналтын тогтолцоо
 - 6.5. Шүүх засаглал
 - 6.6. Хүчний байгууллагын өөрчлөлт
7. **Аюулгүй байдал, гадаад харилцааны бодлого**
 - 7.1. Батлан хамгаалах
 - 7.2. Гадаад харилцаа
 - 7.3. Гадаад хөрөнгө оруулалт
 - 7.4. Гадаад худалдаа



1. МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монголын Хүний Төлөө Нам нь Монгол Улсдаа хүнлэг энэрэнгүй, хүн төвтэй, иргэний эрх зүйт нийгмийг цогцлоож, хууль ёсыг дээдлэн, хөгжил дэвшилд манлайлж, иргэний хяналт бүхий төрийн тогтолцоог байгуулах эрхэм зорилгыг баримтална.

Иргэний хяналтын тогтолцоо нь төрийн албан хаагчдын сахилга бат, ёс зүй, төрийн болон нийтийн хөрөнгөний зарцуулалт, хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих арга, замаар хэрэгжинэ. Түүнчлэн,

Бид:

- 1-рт: Монгол Улсын үлэмж баялаг нь хүн **Та** хэмээн дээдэлнэ;
- 2-рт: Аливаа бодлогыг эрүүл агаар, эрүүл хүнс, эрүүл орчин, эрүүл эрх зүй, эрүүл нийгмийн шаардлаганд нийцүүлэн хэрэгжүүлнэ;
- 3-рт: Тулгар төрийг хүчирхэг, хяналттай, тогтвортой, алсын хараатай, хэтийн бодлогоор цогцлоон байгуулж, Монгол төрийн бахархалыг бүрдүүлнэ;
- 4-рт: Нийтийн эрх ашгаар хувийн эрх ашгийг хязгаарлаж, нийгмийн баялгийг шударга хуваарилан, олигархи бүлэглэлийн эрх мэдэл, хөрөнгө мөнгөний шунал тачаалыг хязгаарлан зогсоож, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлдэг бүтээлч, үйлдвэрлэгч үндэсний дундаж давхаргыг хүчирхэгжүүлнэ;
- 5-рт: Хүчтэй нь хүчгүйгээ захирдаг адгуусны хуулийг халж, соёлт нийгмийг оюун ухаан, амьдралын туршлагаараа залж удирдах, хөдөлмөр чадвараараа манлайлах, мэдлэг, боловсролоо дээдэлсэн, ёс зүйтэй, оюунлаг, нийгмийг цогцлоон байгуулна;
- 6-рт: Хууль цаазын өмнө хэн боловч тэгш эрхтэй байх зарчмыг хангах үүрэгтэй шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төр болон ард түмэн нь эрх мэдлээ хамтран хэрэгжүүлдэг шүүх байгууллагын сонгодог хувилбарыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ;
- 7-рт: Гадаадын аливаа этгээдтэй эрх тэгш, нөхөрсөг харилцааг баримтлах хэдий ч Монгол Улсад Монгол хүний зүй ёсны эрх ашгийг дээдлэн эрхэмлэнэ;
- 8-рт: Ард олны эв нэгдлийг бэхжүүлэн, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгана;
- 9-рт: Өвөг дээдсээс уламжлан ирсэн газар нутаг, их түүх, уламжлалт соёл, байгалийн баялгаа хайрлан дээдэлж, эх орны баялаг, түүхий эдийг боловсруулан, баяжуулах үйлдвэрлэлийн бодлогыг хөхиүлэн хөгжүүлнэ;

хэмээн дурдваас,

Өнө эртний өвөг дээдсийн сургаалыг санаж, ташаарсан алдааг нь давталгүй сургамж хэмээн үзэж, нүүдэлчин удмын суу ухааныг биширч, өнөө цагийн эрдэмтэн судлаачдаа өргөн дээдэлж, Мөнх Хөх Тэнгэрийн ивээл дор **МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМ**-ыг үүсгэн байгуулж, даяар улс олноо зарлан тунхаглав.

УЛААНБААТАР ХОТ

2017 оны 2-р сарын 17-ны өдөр



2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Монголын хүний төлөө намын эрхэм бөгөөд гол зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлд заасан үүргээ бүрэн биелүүлдэг, ёс зүйтэй төрийг цогцлоон бүрэлдүүлэх явдал юм.
- 2.2. Улсын Их Хурал нь зарчим тогтоон хууль гаргаж, Засгийн газар нь хэрэгжүүлдэг эрүүл тогтолцоог хэрэгжүүлдэг зүй тогтлын дагуу Мөрийн хөтөлбөртөө зарчмын асуудлуудыг тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.3. Төрийн тогтвортой, чанартай, зөв, шударга ажиллах нөхцөлийг хангахын тулд Иргэний хяналтын тогтолцоог бүрэлдүүлж бий болгоно.
- 2.4. Улс төр, шүүх, санхүү-эдийн засгийн шинэчлэлийг иж бүрнээр нь хийж улс орноо үсрэнгүй хөгжлийн замд оруулна.
- 2.5. Гишүүдийн тоо, санхүүгийн чадавхиас үл хамаардаг, бодлого боловсруулж хэрэгжүүлэгч улс төрийн намын тогтолцоог бүрэлдүүлэн, улс үндэстэн болон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг алсын хараатай, ойлгомжтой, үр дүнтэй болгох эрхзүйн болон ёсзүйн тогтолцоог бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
- 2.6. Шүүхийн шинэчлэлийн хүрээнд хараат бус байдлыг бодитоор бий болгох, иргэн бүр өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдлэх, төрийн төлөөлөл болсон шүүгч нь ард түмний төлөөлөлтэй хамтран Монгол улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг зарчмыг хэрэгжүүлэх боломжтой эрхзүйн тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.7. Эдийн засгийн бүтцийг оновчтой болгож, нөхөн үрждэг баялагаа арвижуулах, экологийн цэвэр хүнсээр тасалдалгүй хангах хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжиж бодлогыг боловсруулж ажиллахыг эрмэлзэнэ.
- 2.8. Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилгын хариуцлага хүлээдэг эрхзүйн үндсийг бүрдүүлнэ.
- 2.9. Гадаадын офшор дансанд гаргасан авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох хөрөнгө, мөнгийг буцаан авч ирэх хуулийг санаачилан батлуулж хэрэгжүүлнэ.
- 2.10. Нам-Улс төр-Бизнес-Нам гэсэн гинжин холбоог таслан зогсоох, институци бүр бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах эрхзүйн болон ёсзүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.
- 2.11. Төрийн болоод улс төрийн албан хаагчдын орлогоосоо хэт давсан хэрэглээг хянаж, шалгах хуулийг батлуулж, хэрэгжүүлнэ.
- 2.12. Цөөнх нь хөрөнгөжиж, олонхи нь ядуурдаг зарчмыг халж, Иргэн бүрийг баяжихад саад хийхгүй ч буруу баяжвал өршөөхгүй гэсэн шударга зарчмыг хэрэгжүүлнэ.

3. НИЙГЭМ, ЭРҮҮЛ МЭНД, ХАЛАМЖИЙН БОДЛОГО

3.1. Эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх

- 3.1.1. Өвчин туссан хойно нь эмчлэх биш урьдчилан сэргийлж, хамгаалах бодлогыг чухалчилна.
- 3.1.2. Нийтийн биеийн тамирыг дэмжиж, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин, хорооллын төлөвлөлтөнд цэцэрлэгт хүрээлэн, гүйлт, дугуйн зам, усан сан зэргийг заавал тусгах хууль зүйн орчныг бүрдүүлнэ.



3.1.3. ЭМД-н оновчтой, үр дүнтэй, энэрэнгүй хувилбарыг боловсруулж нэвтрүүлнэ.

3.2. Хүн амын өсөлт

3.2.1. Хүн амын өсөлт нь улсын хөгжлийн чухал хэсэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлтийн гол үзүүлэлт гэж үзнэ.

3.2.2. Улсын орны эдийн засгийн чадавхи сайжирч, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх нь хүн амын өсөлтөнд сайнаар нөлөөлөх тул урамшууллын оновчтой бодлого нэвтрүүлнэ.

3.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого

3.3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг эрэлхийлж ашиглана /хүүхэд хүмүүжүүлэн, саатуулж, сургадаг цэцэрлэг, сургууль, өдөр өнжүүлэх нь хүүхдийн эцэг эхэд ажил хийх чөлөө зав олгох үүрэгтэй юм/.

3.3.2. Ажлын байр олноор бий болгож, төсвийн ачааллыг багасгадаг жижиг дунд аж ахуйнуудыг татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

3.3.3. Боловсролын бодлого, мэргэжлийн сургалт, зээлийн бодлого зэрэг нь ажилгүйдлийг багасгахад чиглэгдэх бодлого, зорилгыг хэрэгжүүлэх эрхзүйг таатай орчныг бүрдүүлэхийг төлөө ажиллана.

3.4. Нийгмийн халамж

3.4.1. Нийгмийн халамж нь зорилтот бүлэгтээ чиглэж, хүрч байх бүртгэл тооцооны тогтолцоог бүрдүүлнэ. Халамжийн хавтгайрсан бодлогоос зайлсхийж, бэлэнчлэх сэтгэлгээг багасгана. 1060464

3.4.2. Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг аийх аюулгүй, санаа амар амьдрах нийгмийн тогтолцоог хэрэгжүүлнэ.

4. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГО


4.1. Ерөнхий боловсрол

4.1.1. Боловсролын салбар онцгой салбар, онцгой хандлага, бодлого шаардлагатай суурь салбар. Он цагийн хэлхээсээр харвал ирээдүйг бүтээгч салбар, бид хэн байх, бид юунд бэлэн байх, бид өрсөлдөх чадвартай эсэх, бид хөгжиж чадах эсэхийг тодорхойлох онцгой өвөрмөц салбар гэдгийг ухааран хандах болно.

4.1.2. Боловсролын салбарыг онцгойлон анхаарах бодлого хэрэгжүүлнэ. Ирээдүйд улс орны хөгжлийг тодорхойлох иргэдийг хүмүүжүүлэх, монголчууд юунд бэлдэх, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болгох, цаашдын эрчимтэй хөгжлийг тодорхойлогч салбар хэмээн үзнэ.

4.1.3. Боловсролын тогтолцоог тогтвортой, байнга хөгждөг байдлаар зохион байгуулна. Үндэсний эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр үндэсний онцлогийг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулна. Боловсролын хөтөлбөр нь сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсрол, мэргэжлийн, тусгай, дээд боловсролын зэрэг бүх салбар шатлалыг хамарсан шинжлэх ухаанч, цогц бодлого байна.

4.1.4. Боловсролын салбарын хөгжлийн хөшүүрэг нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлгээ бөгөөд багш, сургагчдын нийгмийн баталгааг сайжруулснаар тэдний нэр хүнд, боловсрол, мэдлэг дээшилж, боловсролтой, соёлтой монгол хүн бэлтгэх тогтолцоо бүрэлдэнэ.

4




- 4.1.5. Бүх хүүхэд, залуучуудын суурь боловсрол эзэмших, сурч хүмүүжих орчин ахуйг ижил тэгш, чанартай нөхцөлөөр хангах чиглэлийг барьж ажиллана.
- 4.1.6. Бидний ирээдүй үеийн хүмүүжил, биеэ авч явах байдал, хүсэл сонирхолд багш нарын жендерийн харьцаа нөлөөлж байгаа гэж үзэж байгаа тул эрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх үр дүнтэй бодлого хэрэгжүүлнэ.

4.2. Мэргэжлийн сургалт

- 4.2.1. Мэргэжлийн сургалт, боловсролын хандлагад эрс өөрчлөлт гаргана.
- 4.2.2. Мэргэжлийн боловсролтой иргэдийг тогтвортой ажлын байраар хангах чиглэлийг барьж ажиллана.
- 4.2.3. Монгол улсыг үйлдвэрлэгч орон болгоход шаардлагатай инженер, техникч, мэргэжлийн ажилчид бэлтгэх чиглэлд өндөр ач холбогдол өгч, бодлого боловсруулахад анхаарна.

4.3. Соёл

- 4.3.1. Үндэсний соёл нь монгол үндэстний оршин тогтнох, уламжлалт онцлогоо хадгалах нандин дархлаа бөгөөд дэлхий дахинд биднийг таниулах хүчирхэг хэрэгсэл хэмээн үзнэ.
- 4.3.2. Соёл урлаг нь хүн төрлөхтний гоо зүй, гоо сайханы мэдрэхүйг хөглөдөг төдийгүй үндэсний өв уламжлалыг таниулах, эх оронч үзэл, бахарлыг төлөвшүүлэх онцгой салбар гэж үзэн бодлогоор дэмжиж, хөгжүүлэх бодлого баримтална.
- 4.3.3. Кино, драмын урлагийн салбар нь арилжааны чиглэлтэй, зөв хүмүүжил, ёс суртахуун, эх оронч үзэл, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжин ажиллана.

4.4. Шинжлэх ухаан

- 4.4.1. Монгол хэл нь монгол сэтгэлгээний үндэс тул эх хэлээ хамгаалах, зөв дэлгэрүүлэх, хөгжүүлэх бодлого баримтална.
- 4.4.2. Шинжлэх ухаан, туршилт нь дээд боловсролыг сайжруулахын зэрэгцээ шинэ нээлт, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх шалгуур үзүүлэлтээр үнэлж дэмжинэ.
- 4.4.3. Түүх, археологийн салбарыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.

4.5. Спорт

- 4.5.1. Нийтийн биеийн тамирыг далайцтай хөгжүүлэх нь бүх нийтийн эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх төдийгүй дэлхийд түвшинд амжилт гаргах авьяаслаг тамирчдыг бэлтгэх суурь хэмээн үзэж, тэдний амжилтаас улбаалан, улс үндэстнээ дэлхий нийтэд сурталчлан, таниулах бодит үйл хэрэг болгоно.
- 4.5.2. Мэргэжлийн болон их спортыг дэмжих бодлого баримтлана.

5. ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО

5.1. Төсөв, санхүү

- 5.1.1. Эдийн засаг үйлдвэрлэлийн бодлогын шинэчлэл, сайжруулалтын хүрээнд эх орны түүхий эд дээр суурилсан үйлдвэрлэлийг дэмжих, нөхөөн сэргээгдэх баялгийн ашиглалтыг сайжруулах, уул уурхайн өгөөжийг нийтээр шударгаар хүртэх тогтолцоог бий болгоно.



6.4.2. Хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйг сахиулдаг иргэний хяналтын тогтолцоог байгуулна.

6.5. Шүүх засаглал

6.5.1. Бүх шатны шүүгчид нь хараат бусаар, шударгаар ажиллах боломжтой шүүхийн тогтолцоог бий болгох хууль эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.2. Монгол улсын нэрийн өмнөөс төрийн төлөөлөл шүүгч, ард түмний төлөөлөл нар хамтран шийдвэр гаргадаг тогтолцоог сэргээнэ.

6.5.3. Шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төрийн төлөөлөл болох шүүгч нь ардын төлөөлөгчтэй хамтран, хараат бус, шударга шийдвэр гаргадаг байх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.4. Хүн өөрийгөө болон бусдыг өмгөөлөх эрхийг чөлөөтэй болгож нээнэ.

6.6. Хүчний байгууллагын шинэчлэл

6.6.1. Хууль хяналтын байгууллагууд “Гүйцэтгэл – цагдаа, хяналт – прокурор, шийдвэр – шүүх” гэсэн схемийн дагуу хараат бус, шударгаар үйл ажиллагаа явуулдаг байх хууль эрхзүйн таатай орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

7. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

7.1. Батлан хамгаалах

7.1.1. Хугацаат цэргийн алба нь батлан хамгаалахын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ залуучуудыг эх оронч сэтгэлтэй, бие бялдар, хүмүүжлийн өв тэгш хөгжилтэй, хамтран ажиллах чадвартай, бүтээн байгуулах тэмүүлэлтэй болгох сургалт хүмүүжлийн оновчтой хөтөлбөр байхаар хэрэгжүүлнэ.

7.2. Гадаад харилцаа

7.2.1. Төвийг сахих, эвсэлд үл нэгдэх, цөмийн зэвсэггүй бүс байх уламжлалт бодлогоо баримтлахыг чухалчилна.

7.2.2. Дипломат харилцаа нь аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангах, бүх салбар дахь харилцааг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой ажиллана.

7.2.3. Дэлхийн аль ч улсад Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах бодлогыг баримтлана.

7.3. Гадаадын хөрөнгө оруулалт

7.3.1. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж дэлхийн түвшинд дүйцүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

7.3.2. Дотоодын зах зээлд хамгаалах шаардлагатай чухал салбарыг тодорхойлж, уг салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын хэт давамгайл байдлыг хязгаарлана.

7.4. Гадаад худалдаа

7.4.1. Мөнхийн 2 хөрштэйгээ харилцан ашигтай, оновчтой харилцаа, худалдааны бодлогыг баримталж харьцана.

7.4.2. Гадаад худалдааны гэрээ, бодлогоор дотоод үйлдвэрлэлээ хөгжүүлэх чиглэл, захиалга хийдэг тогтолцоог үүсгэнэ.

< ----- >



